

**“ЖИНХУА ОРД” ХХК-НИЙ ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
НУТАГТ ОРШИХ MV-006701 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙД “ДӨРВӨЛЖИНГИЙН ТӨМРИЙН
ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-006701/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5002486/

Улаанбаатар хот

2025 он

БАТЛАВ:

БОУАӨЯ-НЫ ХБОБХГ-Н ДАРГА:

Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ЖИНХАУ ОРД” ХХК, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Б.ЧУЛУУН

“ЖИНХУА ОРД” ХХК-НИЙ ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
НУТАГТ БАЙРЛАХ “ДӨРВӨЛЖИНГИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ
ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-006701/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5002486/

ХЯНАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛТАН:

Н.ЖАРГАЛСАЙХАН

УЛААНБААТАР ХОТ

2025 ОН

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ГАРЧИГ

ОРШИЛ.....	5
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	6
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРШИЛ	7
4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ...	11
5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	13
6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
8. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	35
10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	35
11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	36
12. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	38
13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	42
14. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	43
15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ.....	47
16. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА.....	48
17. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТ	49

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг.1. Ордын байршлын зураг.....	7
Зураг.2. Илүү газар ашиглалтыг тодорхойлсон зураг.....	21
Зураг.3. Илүү газар ашиглалтыг тодорхойлсон дроны боловсруулалтын зураг	22
Зураг.4. Илүү газар ашиглалтыг тодорхойлсон дроны боловсруулалтын зураг	23
Зураг.5. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг,	24
Зураг.6. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг,	25
Зураг.7. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг,	26
Зураг.8. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг,	27
Зураг.9. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг,	28
Зураг.2. Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим	38
Зураг.3. Ажилчдын хотхоноос гарах хаягдлын ангилалт	39
Зураг.4. Үйлдвэрлэлээс гарах хаягдлын ангилалт.....	40
Зураг.5. Агаарын мониторингийн байршил, Тайлбар: А-1,2 – Агаарын дээж авсан цэг	44
Зураг.6. Хөрсний дээж авах цэгийн байршил, Тайлбар: Х-1,2,3 – Хөрсний дээж авсан цэг	45

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт .1. Төслийн байршлын координат	7
Хүснэгт .2. 2023 оны ордын үйлдвэрлэлийн нөөц.....	9
Хүснэгт .3. Баяжмал үйлдвэрлэлтийн төлөвлөгөө	10
Хүснэгт 4. Уулын ажлын төлөвлөгөөний төлөвлөлт, 2024 онд.....	10
Хүснэгт 4.36. Газар чөлөөлөх ажлын график	21

ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Жинхау Орд” ХХК-ний Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших ашиглалтын MV-006701 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайд “Дөрвөлжингийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа 2023 онд батлагдсан БОННУ-ний тайлан, Хэнтий аймгийн засаг даргын “Энхзоо” ХХК-тай байгуулсан Нийгмийн хариуцлага, байгаль орчны чиглэлээр хамтран ажиллах гэрээ, АМГТГ-с батлагдсан уурхайн 2024 оны уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан шинэ дүрэм, журам, стандартууд, БОАЖЯ-ны сайдын 2019-10-29-ны №А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэрэг эрх зүйн баримт, материалууд дээр үндэслэн боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр “Дөрвөлжингийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь зөвхөн төслийн ашиглалтын үйл ажиллагаанд үндэслэн 1 жилийн хугацаатай /2024 он/ хийгдсэн бөгөөд холбогдох бусад бүхий л ажиллагааг байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй нь нягт уялдуулан ажиллах нь зайлшгүй шаардлагатай юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж тэднээр хэлэлцүүлсний дараа, жил бүр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавих шаардлага, хүсэлтийг хэрхэн хангасныг нэгтгэн хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлтийн үр дүнгийн тайланг тухайн оны 12-р сард багтаан БОАЖЯ-нд ирүүлсний дараа, дараа жилийн төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардлын хэмжээг батална.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: MV-006701 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайд “Дөрвөлжингийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах”

Төслийн зорилго: Дөрвөлжингийн төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийн хүрээнд төмрийн хүдрийн үлдэгдэл нөөцийг ил аргаар олборлон, бутлан, ангилах, хуурай соронзон баяжуулалтын дамжлагаар таваарын бүтээгдэхүүн үйлдвэрлэн, бүтээгдэхүүнийг экспортлох, улс орон болон бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах, ажлын шинэ байр бий болгох зорилготой.

Төслийн ач холбогдол: Дөрвөлжингийн төмрийн хүдрийн орд газрын үлдэгдэл нөөцийг зөв зохистой олборлон эдийн засгийн эргэлтэнд оруулах нь Монгол улс, ялангуяа бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах, экспортоор үйл ажиллагаа нь МУ-ын валютын нөөцийг нэмэгдүүлэх, гадаад худалдааны орлогыг нэмэгдүүлэхээс гадна МУ-ын тогтвортой хөгжлийн бодлогыг хангахад чиглэсэн төр захиргааны байгууллагуудаас хэрэгжүүлж буй “МУ-н тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”, “Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” зэрэг бодлогын бичиг баримтуудын үзэл санаа, тэдгээрийн зорилготой нийцнэ.

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:

“Жинхуа Орд” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9019004016

Регистрийн дугаар: 5002486

Хаяг: Улаанбаатар, Баянгол, 14-р хороо, 47 тоот


Утас: 99265803

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРШИЛ


“Жинхуа орд” ХК-ний Ашигт малтмал ашиглалтын MV-006701 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий Дөрвөлжингийн төмрийн хүдрийн орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 320 км, Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрээс баруун тийш 13 км, төмөр замын Айраг өртөөнөөс зүүн хойш 75 км -т Хэнтий аймгийн Дархан сумын нутаг, Хөх овоотын толгодод байрлана.

Хүснэгт .1. Төслийн байршлын координат

№	Е	Н
1	109°18'51.71"	46°12'41.65"
2	109°18'21.72"	46°12'41.65"
3	109°18'21.72"	46°13'11.65"
4	109°18'51.71"	46°13'11.65"



“Жинхуа орд” ХХК-ний Хэнтий аймгийн Дархан сумын нутагт хэрэгжиж буй “Дөрвөлжингийн төмрийн хүдрийн орд” ил аргаар ашиглах” төслийн ерөнхий байршил



Төслийн талбайн цэгийн координат

Цэг	Xg	Xm	Xs	Yg	Ym	Ys
1	109	18	51.71	46	12	41.65
2	109	18	21.72	46	12	41.65
3	109	18	21.72	46	13	11.65
4	109	18	51.71	46	13	11.65

Таних тэмдэг



Зураг.1. Ордын байршлын зураг

3. ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТ

Олборлолт: Дөрвөлжингийн уурхай нь 3-р сарын 1-ээс хөрс хуулалт, хүдэр олборлолтын ажлыг эхлүүлэн ажиллана. 2024 онд 30.6%-ийн агуулга бүхий 400 мян.тн төмрийн хүдэр олборлож, 516.8 мян.м3 хөрс хуулалтын ажил хийхээр төлөвлөсөн.

Баяжуулалт: Төмрийн хүдрийг хуурай соронзон баяжуулалтын аргаар баяжуулах ба нийт 42.9%-ийн агуулгатай 252.24 мян.тн төмрийн баяжмал гарган авна.

Хаягдал: Баяжуулах үйлдвэрийн хаягдалыг тусад хуучин хаягдлын овоолготой нэгтгэн овоолно. 2024 онд 9%-ийн дундаж агуулагатай 147.76 мян.тн хаягдал гарна.

Эдийн засаг: 2024 онд 47.93 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж 19.6 тэрбум төгрөгийн зардал гаргаж 22.15 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллана.

2023 ОНЫ УУРХАЙН АШИГЛАЛТ

Уул уурхайн үйлдвэрлэл байгуулах үндэслэл: Дөрвөлжингийн төмрийн хүдрийн ордод 2003-2004 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн, АМГТХЭГ-ын даргын 2007 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 178 дугаар тушаал, ЭБМЗ-ийн 2007 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 5-01 дугаар тоот дүгнэлтээр төмрийн хүдрийн нөөцийг бодитой /В/ зэргээр 2,411.5 тонн, боломжтой /С/ зэргээр 1,702.4 тонноор тус тус тогтоон улсын нэгдсэн санд бүртгэсэн.

Ордыг ил аргаар 2010-2011, 2013-2015 онуудын хооронд олборлолт явуулсан бөгөөд уулын ажлын мэдээ, тайлангаар бодитой В зэрэглэлээр нийт 955.64 мянган тонн, боломжтой С зэрэглэлээр 310.64 мянган тонн, нийт 1,266.28 мянган тонн төмрийн хүдрийн нөөцийг олборлосон.

2003-2004 онд бодогдсон тайланд алдаа байсан гэж үзэн Дөрвөлжингийн төмрийн хүдрийн ордын нөөцийг бататгах зорилгоор 2021 онд нэмэлт нөөцийн тодотгол тайлан боловсруулж, тайланг ЭМБЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн, Үндэсний геологийн албаны даргын 2022 оны 03-р сарын 03-ны өдрийн 19 дугаар тушаал, ЭБМЗ-ийн 2021 оны 12-р сарын 22-ны өдрийн ХХ-15-11 дугаар дүгнэлтээр ордын нөөцийг бодитой В зэрэглэлээр 1,805.51 мянган тонн, боломжтой С зэрэглэлээр 611.50 мянган тонн, нийт 2,417.01 мянган тонн нөөцийг улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.

Орд газрыг ашиглах аргын сонголт, үндэслэл: “Дөрвөлжин” орд нь хөрс хуулалт бага, уул-техник нөхцөл энгийн, хялбар орд бөгөөд олборлолт явагдах талбайн гадаргуун түвшин нь далайн түвшингээс дээш 1295-1325 м өргөгдсөн, газрын гадарга нь харьцангуй жигд, өндөржилтийн зөрүү багатай талбайд оршино.

Ил уурхайн ашиглалтын систем:

Ордыг тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр олборлоно. Шимт хөрсийг түрэх техникээр хуулах бол үлдсэн хөрсийг тэсэлгээний ажлаар бутлан сийрэгжүүлж ухаж ачин, тээвэрлэж хөрсний овоолгуудад буулгана. Төмрийн хүдэр нь М.М.Протоdjяконовын ангиллаар 10-12 бат бөхийн коэффициенттай чулуулагт орох ба төмрийн хүдэр олборлолт өрөмдлөг, тэсэлгээгээр бэлтгэгдэнэ. Тэслэгдсэн төмрийн хүдрийг экскаватор

автосамосвалын хослолоор тээвэртэй ашиглалтын системээр ухаж ачин, тээвэрлэх ба хуурай соронзон аргаар баяжуулна.

Үйлдвэрлэлийн нөөц: 2024 онд ордын дээд түвшингүүдийн хөрс хуулалтын ажил хийгдэж ордын хойд хэсгийн блокуудаас олборлолтын ажлыг эхлүүлнэ.

Хүснэгт .2. 2023 оны ордын үйлдвэрлэлийн нөөц

Ашиглалтын түвшин	Үйлдвэрлэлийн нөөцийн зэрэг, В	Үйлдвэрлэлийн нөөц			
		Хүдрийн хэмжээ	Дундаж агуулга	Металл, Ре	Хуулах хөрсний
М		МЯН.ТН	%	МЯН.ТН	МЯН.М ³
1300-1310(В)		41.42	30.70	12.72	60.28
1290-1300(В)		155.58	31.60	49.16	233.43
1280-1290(В)		114.86	30.36	34.88	115.30
1290-1300(С)		38.39	30.10	11.71	58.36
1280-1290(С)		49.22	28.50	14.03	49.41
Нийт		400.00	30.62	122.50	516.78

Уурхайн ажлын горим: Ил уурхайн ажиллах горим нь цаг агаар, уур амьсгал, уурхайн үндсэн техник тоног төхөөрөмжийн бүтээл, жилийн хүчин чадал зэргээс ихээхэн шалтгаална. Уурхайн жилийн хүчин чадлаас хамааран уулын ажил өдөрт 2 ээлжээр явагдана, ээлж үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Уулын ажлын хувьд дулааны улиралд буюу 5-р сарын эхнээс 10 сарыг дуустал нийт 6 сар уулын ажлыг явуулна.

Хөрсний овоолго болон хүдрийн агуулах:

Дөрвөлжингийн төмрийн хүдрийн ордыг ашиглах үйл ажиллагаанаас үүсэх хөрсний овоолго болон төмрийн хүдрийн агуулахыг уурхайн өөрийн тусгай зөвшөөрлийн талбайд байрлуулахаар төлөвлөсөн. Уул техникийн болон байгаа техникийн боломж, нөхцөлүүд зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан үзэж бульдозерын захлах хэлбэрийн овоолгууд үүсгэнэ. Уурхайн гүнд нөөц өсөх магадлалтай байгаа ба ашиглалтын үеийн хайгуулын ажил хийгдэх тул дотоод овоолго үүсгэхгүй. Уурхайгаас гарах хөрс нь бага, үүсэх хөрсний гадаад овоолгын өндөр нь 10 м, 1 давхаргатай үүсгэхээр тооцсон.

Уулын бусад туслах процессууд:

Төслийн хүрээнд дараах туслах процессуудтай. Үүнд:

- Зам, талбайн ажил, арчилгаа
- Ус зайлуулалт
- Үер усны хамгаалалт
- Тоосжилт дарах

Зам талбайн ажил, арчилгаа: Ил уурхайн дотоод тээврийн авто замыг бульдозероор түрж хийх ба замыг засаж тэгшлэх, арчлах зэрэг ажлуудыг автогрейдерээр хийж гүйцэтгэнэ. Ил уурхайн дотоод тээврийн замын ашиглалт үйлчилгээний ажлыг гэрээт компани автогрейдерийг ашиглана хийж гүйцэтгэнэ. Зам засвар, ашиглалт, үйлчилгээний ажилд зам тэгшлэх, замын бартаа саадыг арилгах, замын эвдрэлийг засах, замыг усны үерээс хамгаалах зэрэг ажлууд орно.

Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо:

“Жинхау Орд” ХХК-ийн Дөрвөлжингийн уурхайн хуурай баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөөг үйлдвэрлэлийн нийт үлдэгдэл нөөцөд тулгуурласан ба 29.95 хувийн дундаж агуулгатай 2,447.65 мянган тонн хүдэр баяжуулж 42.9 хувийн агуулгатай 1,491.86 мян.тн баяжмал үйлдвэрлэнэ.

Хүснэгт .3. Баяжмал үйлдвэрлэлтийн төлөвлөгөө

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он
1	Баяжуулах хүдрийн хэмжээ	мян.тн	400.0
2	Анхдагч хүдрийн агуулга	%	30.62
3	Баяжмалын хэмжээ	мян.тн	252.24
4	Баяжмалын гарц	%	63.06
5	Баяжмалын агуулга	%	42.90
6	Баяжмалын металл авалт	%	88.35
7	Хаягдлын агуулга	%	9.66
8	Хаягдлын гарц	%	36.94
9	Хаягдлын хэмжээ	мян.тн	147.76

2024 онд дунджаар 9.66 хувийн агуулгатай 147.76 мянган тонн хаягдал үүснэ.

Хуурай баяжуулалтынн техник, тоног төхөөрөмж:

Хуурай баяжуулах үйлдвэр нь олборлосон хүдрийг 3 шатны бутлагаа, баяжуулалтын технологийн схемээр баяжуулна. Үйлдвэр 1 нь цагт 45 тн, үйлдвэр 2 цагт 50 тн хүдэр боловсруулах бөгөөд баяжуулалтын үр дүнд баяжмал хаягдал гэсэн хоёр бүтээгдэхүүн гаргана.

2024 оны уулын ажлын төлөвлөгөөний төлөвлөлт

Хүснэгт 4. Уулын ажлын төлөвлөгөөний төлөвлөлт, 2024 онд

Үзүүлэлт		Хэмжих нэгж	Тоон утга	Сар										Улирал			
Бүтээгдэхүүний төрөл	Ашигт малтмалын нэр			3	4	5	6	7	8	9	10	11	12	I	II	III	IV
1	2	3	4	9			10	11	12	13	14	15	16	17	18	19	20
Олборлолт																	
Хөрс хуулалт		мян.м3	516.78	45.50	45.50	52.00	58.50	65.00	65.00	58.50	52.00	42.25	32.53	45.50	156.00	188.50	126.78
а. Бэлтгэл малталт		мян.м3	0.00											0.00	0.00	0.00	0.00
б. Үндсэн малталт		мян.м3	0.00											0.00	0.00	0.00	0.00
Хүдэр (элс) олборлолт		мян.тн	400.00	66.50			67.10	67.20	66.80	67.00	66.30			0.00	133.60	201.00	66.30
	Төмөр (Fe)	мян.тн	122.48	20.61			20.79	20.83	20.70	20.76	20.55			0.00	41.40	62.29	20.55
Бүтээгдэхүүн гаргалт																	
Хүдэр (элс) боловсруулалт		мян.тн	400.00	66.50			67.10	67.20	66.80	67.00	66.30			0.00	133.60	201.00	66.30
	Төмөр (Fe)	мян.тн	122.48	20.61			20.79	20.83	20.70	20.76	20.55			0.00	41.40	62.29	20.55
Төмрийн бүхэллэг баяжмал		мян.тн	252.82	41.94			42.32	42.38	42.13	42.25	41.81			0.00	84.25	126.76	41.81
	Төмөр (Fe)	мян.тн	108.46	17.99			18.15	18.18	18.07	18.13	17.94			0.00	36.14	54.38	17.94
Бүтээгдэхүүн борлуулалт																	
Төмрийн бүхэллэг баяжмал		мян.тн	252.24	41.94			42.32	42.38	42.13	42.25	41.81			0.00	84.25	126.76	41.81
	Төмөр (Fe)	мян.тн	108.21	17.99			18.15	18.18	18.07	18.13	17.94			0.00	36.14	54.38	17.94
а. Дотоод		---															
		мян.тн	0.00											0.00	0.00	0.00	0.00
б. Экспорт		---															
Төмрийн нунтаг баяжмал		мян.тн	252.24	41.94			42.32	42.38	42.13	42.25	41.81			0.00	84.25	126.76	41.81
	Төмөр (Fe)	мян.тн	108.21	17.99			18.15	18.18	18.07	18.13	17.94			0.00	36.14	54.38	17.94

4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Жинхау Орд” ХХК-ний төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг төслийг хэрэгжүүлэх байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тодорхойлсон байдаг.

Хүдрийн тээвэрлэлт, тэсэлгээ зэрэг төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан, ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

2.1. Агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Гол сөрөг нөлөөллүүд:

- Хүдрийн олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаа болон хөдөлгөөнт эх үүсвэрээс агаарт PM10-аас жижиг хэмжээтэй нарийн ширхэгт тоосонцорын хэмжээ ихсэх
- Элэгдэл эвдрэлд өртсөн газраас салхины нөлөөгөөр тоосжилт үүсэх
- Тэсэлгээ, уурхайд ажиллаж байгаа техник, тоног төхөөрмжөөс үүсэх дуу шуугиан, тоосжилт
- Бага оврын халаалтын зуух, хүнд даацын болон бусад техникээс бохирдуулагч хий үүсэх

Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Зам эвдрэх, зам засах зэргээс шалтгаалан шороон зам гарган ашигласнаас агаарт тоосжилт үүсэх
- Шатахуун түгээх станцаас болон тос тосолгооны материалын агуулахаас нэвчилт үүсэх, байгалийн гамшгийн улмаас тос тосолгооны материал алдагдсанаас агаарт ууршин тухайн орчны агаарыг бохирдуулах.

2.2. Усны чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Уурхайн хотхон болон ажилчдын кемпийн бохир ус цэвэрлэх байгууламжийн эвдрэл гэмтэл, технологийн горим алдагдсанаас үүдэн гадаргын болон газрын доорх усны чанар найрлагад нөлөөлөх.
- Шатахуун түгээх станцын агуулахаас нэвчилт үүсэх, байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас хөрсөнд нэвчин уст үеийг бохирдуулах.
- Хаягдал чулуулгийн овоолго дахь хүчил шүлтийн тэнцвэр алдагдаж хүчиллэг урсацын нөлөөгөөр гадаргын болон газрын доорх ус бохирдох.

2.3. Хөрсний чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Гол сөрөг нөлөөлөл:

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын хэлбэр төрхөд өөрчлөлт орох.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орох.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Салаа зам үүсгэснээс шалтгаалан хөрс элдэгдэл, эвдрэлд орох.
- Тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан хөрс бохирдох.
- Хуурай хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох.
- Борооны усны угаагдал, үерийн усны улмаас бохирдол зөөгдөн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.

2.4. Ургамлан бүрхэвчид үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Гол сөрөг нөлөөлөл:

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын ургамлан бүрхэвч усах.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орж тухайн хэсгийн ургамлан бүрхэвч доройтох.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Салаа зам үүсгэснээс шалтгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орж ургамлан бүрхэвчид нөлөөлөх.
- Тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан ургамлын ургалтанд нөлөөлөх.
- Төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилт ургамлын гадаргууд бууснаар фотосинтезийн процессийг багасгаж ургамлын ургалтанд нөлөөлөх

2.5. Биологийн төрөл зүйлд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Гол сөрөг нөлөөлөл:

- Уул уурхай түүнийг дагасан суурьшлын бүсээс тухайн бүс нутгийн амьтан дайжих, дүрвэх.
- Уурхайн хөрс хуулалт, хашаажуулалт зэргээс амьтны амьдрах орчин, идэш тэжээл хязгаарлагдах.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

Тээврийн зам хөндлөн гарах амьтад машинд дайруулах.

5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тус төслийн өмнөх байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан болон төслийн талбайд хийсэн хээрийн судалгаа, шинжилгээний дүн зэргийг үндэслэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг боловсруулав. ТЭЗҮ-д тусгагдснаар уурхай ойролцоогоор 7 жил ажиллах болно. Мөн уурхайн уул-техникийн ажлын нөхцөл зэргийг харгалзан үзвэл нөхөн сэргээлтийг уурхайг ашиглаж дуусны дараа хийхээр байгаа тул ашиглалтын явцад байгаль хамгаалах болон дүйцүүлэн хамгаалалын ажлыг сайтар хийж байх нь зүйтэй болно. Энэ нь уурхайн ажиллагаа дуусны дараа нөхөн сэргээлт хийхтэй холбоотой юм.

Энэхүү төлөвлөгөөний дагуу 2024 онд болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөллүүдээс сайтар сэргийлэн ажиллах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх, хог хаягдлын сайтар бэлтгэгдсэн менежмент, зайлуулах устгах системтэй болох зэрэг байх болно.

- Уурхайн дотоод үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилтийг бууруулах
- Болзошгүй эрсдэл, хүчиллэг урсац бүхий үерийн үед ажиллах төлөвлөгөөтэй болох
- Хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах, устгах системийг бий болгох
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх
- Үйл ажиллагааны явцад учирч болзошгүй эрсдэл аюулаас бүрэн сэргийлж ажиллах, энэтэй холбоотой сургалтыг тогтмол зохион байгуулах
- Илүү ашиглалт бүхий талбайг тодорхой хэмжээгээр чөлөөлөх

6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төлөвлөгөөний гол зорилго нь дээр тодорхойлсон голлох сөрөг нөлөөллүүдийг бууруулах оршино. Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа дээрх төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлийн товч тодорхойлолт болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт зэргийг үндэслэн хийв.

2.6. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

#	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ төг	Нийт зардал төг	Хэрэгжү үлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
1	Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор тусгай зориулалтын бодис хэрэглэх	Ил уурхай	m ³ /сар	Жил бүр	Үйлдвэрлэлийн зардлаас		Жинхуа орд ХХК	-	Шаардлагатай нөхцөлд усалгаа хийгдсэн байх	Агаарын тухай хууль, MNS 4585:2007
2	Уурхайн технологийн замын засвар үйлчилгээг тогтмол хийж үүсэх тоосжилтын хэмжээг бага байлгах		m ³					-	Замын засвар үйлчилгээ тухай бүр хийгдсэн байх	
3	Уурхайн тээврийн машины хурдны хязгаарт хяналт тавьж, үүсэх тоосыг бага байлгах		-	Өдөр бүр				-	Машины хурд тогтоосон хязгаараас хэтрээгүй байх.	
4	Техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, техникийн хэвийн ажлын горимыг ханган тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хийг үйлдвэрлэгчээс гаргасан хэм хэмжээнд байлгах	Төслийн талбайн хөнгөн тэрэгнүүд	ширхэг	10	Үйлдвэрлэлийн зардлаас			Байгаль орчны баг	Улсын үзлэгт хамрагдаж Холбогдох төлбөрийг төлсөн байх	АТ Хууль АБТТ Хууль
5	Гадаад тээврийн замын арчилгааг байнга хийж байх	уурхайгаас Засмал зам хүртэл зам	10 км	Тухай бүр	Үйлдвэрлэлийн зардлаас			Байгаль орчны баг	Шороон замаар тээвэр хийсэн тохиолдол гараагүй байх	БОХТ Хууль
6	Агаарын тоосжилт буюу PM2.5, 10 хэмжигч 1 цэг байршуулах	Уурхайн хүрээ болон нөлөөллийн бүс	ш	1	Дотоод зардлаас төлөвлөх					
БОМТ-ний зардал, төг								-		

2.7. Газар доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

#	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт	
1	Усны нөөцийг алдагдалгүйгээр ашиглах зорилгоор уурхайн шүүрлийн усны шавхалтыг хамгийн их байх горимыг мөрдөн ажиллаж, уг усыг зам усалгаа болон мод усалгаанд ашиглах	уурхай	м³	500	Үйлдвэрлэлийн зардлаас		Жинхуа орд ХХК	-	Уурхайн шүүрүүлэлтийн систем горимын дагуу ажилласан байх	Усны тухай хууль	
2	Газар доорх усны хяналт шинжилгээг малчдын худгууд дээр хуваарийн дагуу хийж гүйцэтгэх	Уурхай орчим	хүн/ өдөр	2	Орчны хяналт шинжилгээний зардлаас			Усны лабораториуд	Хэмжилт, дээжлэлт хуваарийн дагуу хийгдсэн байх	БОНБҮТХ	
3	Булгийн эх ба уст цэгүүдийг цэвэрлэх арга хэмжээ зохион байгуулах	Төслийн талбай орчмын уст цэгүүд	хүн/ өдөр	2	250 000	500 000		Төслийн нэгжүүд	Жилд 2-с доошгүй уст цэгүүдийг цэвэрлэсэн байх	Усны тухай хууль	
БОМТ-ний зардал, мян.төг					500 000						
Үйлдвэрлэлийн зардал					-						

2.8. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

#	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
1	Түлш, шатах тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих, асгаралт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах арга хэмжээ авч ажиллана.	Төслийн талбай	удаа	12	Үйлдвэрлэлийн зардлаас		Байгаль орчны баг	Төслийн нэгжүүд	Хөрсний шинжилгээний дүн стандартын шаардлага хангаж байх	ХХЦСТ Хууль, MNS 5850:2008
2	Салаа зам үүсэхээс хяналт тавьж, хөрсний элэгдэл эвдрэл үүсэхээс урьдчилан сэргийлнэ	Төслийн талбай	хүн/өдөр	12			Байгаль орчны баг	Төслийн нэгжүүд	Төслийн нөлөөллөөр салаа зам гараагүй байх	ХХЦСТ Хууль, ГТХууль
3	Хөрсний төлөв байдал ба бохирдлын мониторинг судалгаа хийж хэрэгжүүлэх	Уурхайн орчмын бүс	Удаа	2	Орчны хяалт шинжилгээний зардлаас		Байгаль орчны баг	Мэргэжлийн байгууллага	Шинжилгээний дүн, Тайлан гарсан байх	БОНБУТХ MNS 5850:2008, MNS 3297:1991
4	Үер болон борооны усаар зөөгдөн элдэв хог хаягдал хөрсөнд шингээгдэхээс сэргийлж үерийн ус зайлуулах суваг, шуудуу байгуулах	Төслийн талбай болон түүний орчимд	-	-	-	Үйлдвэрлэлийн зардлаас	Уулын үйлдвэрлэлийн хэсэг, байгаль орчны баг	Төслийн нэгжүүд	Үйлчлэлийн нөлөөгөөр	
БОМТ-ний зардал					-					
Үйлдвэрлэлийн зардал					-					

2.9. Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

#	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
1	Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх	Төслийн талбай	Удаа	1	3 000 000		Мэргэжлийн судлаач, байгууллага	Байгаль орчны баг	Тайлан гарсан байх	БОНБУТ Хууль
2	Амьтны аймгийн мониторинг судалгааг том хөхтөн амьтан, шувууд зэрэг чиглэлээр хийж хэрэгжүүлэх	төслийн талбай	Удаа	1	2 000 000		Мэргэжлийн судлаачид, байгууллага	Байгаль орчны баг	Тайлан гарсан байх	БОНБУТ Хууль
БОМТ-ний зардал, мян.төг					5 000 000 төгрөг					
Үйлдвэрлэлийн зардал					-					
Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний нийт зардал, мян.төг					5 500 000.0					

Ургамлан нөмрөгийн хяналт, шинжилгээ

Уурхайн үйл ажиллагааны явцад ургамлын аймаг, ургамлан нөмрөгийн хяналт шинжилгээ, судалгааг сонгосон цэгүүдэд, тодорхой давталттайгаар, тогтмол явуулсанаар цөлөрхөг хээрийн өвөрмөц экосистемд дасан зохицож ирсэн ургамлан нөмрөг, түүний зүйлийн олон янз байдлын хомсдолыг хянах, ургамлын бүлгэмдэлд өөрчлөлт орж байгаа эсэх, хөл газрын ургамлын оролцоо нэмэгдэж байгаа болон ургамлын бүтээмж хэрхэн өөрчлөгдөж байгаа зэргийг илрүүлэх боломжийг олгоно. орд нь байгаль орчны салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, стандарт, журам зэрэг эрхзүйн баримт бичгүүдээс өөрсдийн үйл ажиллагаатай холбоотойг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Уурхайн талбайд ургамлан нөмрөгийн мониторингийн цэг сонгон авч ургамлын хяналт-шинжилгээ, мониторингийн судалгааг тогтмол хийх хэрэгтэй

Хяналт шинжилгээг явуулахдаа сонгон авсан цэгүүдэд аргазүйн дагуу тодорхой хуваариар хэмжилт бүртгэл хийх ба ургамлан нөмрөгт олборлолтын болон байгалийн зүгээс үзүүлж буй нөлөөг тогтоох шаардлагатай. Хяналтын цэгийг сонгохдоо ургамлан бүлгэмдэл солигдлын дагуу шугаман трансектийн дагуу явж ургамлан бүлгэмдэл өөрчлөгдөх тутамд хяналтын цэг сонгоно. Ургамлан нөмрөгийн хяналт шинжилгээг ургамлын өсөлт хөгжлийн үе буюу 6-8 сард хийнэ. Ингэхдээ сонгосон хяналтын цэгт 3 удаагийн давтамжтайгаар геоботаникийн бүрэн бичиглэлийг Браун Бланкийн бичиглэлийн аргаар үйлдэнэ. Бичиглэлд ургамлын төрөл зүйл, тохиолдоц, арви, бодгалийн тоог үнэлнэ. Мөн бүлгэмдлийн биомассыг хуурай жингийн аргаар тодорхойлно.

Хяналт шинжилгээг дараах чиглэлээр хэрэгжүүлэх. Үүнд:

- Хөндлөнгийн-Мэргэжлийн байгууллагаар хийлгэх
- Дотоод-Уурхайн байгаль орчны мэргэжилтнүүд хийх,
- Олон нийтийн оролцоотой хийх зэрэг болно.

Хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр

Уурхайн олборлолт эхлэхээс өмнө мэргэжлийн эрдэмтэн, судлаачдаар ургамлын аймаг, ургамалжилтын хяналт шинжилгээ, мониторингийн судалгааг тухайн уурхайн байгаль орчны суурь болон нарийвчилсан үнэлгээнд суурилсан байдлаар боловсруулалт хийлгэн, тэнд сонгогдсон байршил, аргазүй, давтамжийн дагуу тогтмол хийлгэнэ. Энэ нь олборлолтын өмнөх суурь нөхцлөөс, төсөл хэрэгжиж дуусах хүртэлх ургамлан нөмрөгт нөлөөлсөн нөлөөллийг нарийн тогтоох боломжийг олгодог.

Дотоод хяналт шинжилгээ

Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөрийг уурхайн байгаль орчны мэргэжилтнүүд мэргэжлийн байгууллагын боловсруулсан хөтөлбөрийн дагуу дотоодын ажиглалт судалгааг явуулж, нэмэлт мэдээ материал цуглуулна. Ингэхдээ нөлөөллийн болон нөлөөллийн бус бүсэд сонгон авсан мониторингийн цэгүүдийн хооронд 50 м-ийн зайтай байх. Өөрөөр хэлбэл нэг цэгт 2 удаагийн давталттайгаар мониторингийг хийнэ. Жил бүрийн мониторингийн үр дүнг нөлөөллийн үр дүнтэй харьцуулж, ямар нэгэн сөрөг нөлөөллийн улмаас үүссэн өөрчлөлт ажиглагдвал түүнийг бууруулах, хянах арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх. Хөрс, ургамал болон усны мониторингийн үр дүнгүүдийг хооронд нь уялдуулан, дүгнэлт гаргаж нөлөөллийг тодорхойлох.

Сонгогдсон цэгүүдэд мониторинг хийхдээ эдгээр нөлөөллийн бүсийн цэгүүд нь нөлөөллийн бус бүсэд сонгогдсон цэгүүдтэй нэг хэвшинжийн ургамалжилт эсвэл бүлгэмдэлд хамаарагдаж байгаа эсэхийг ажиглах. Тухайлбал, нөлөөллийн бүс дэх цэг нь сайрын ургамалжилт бүхий талбайд, нөлөөллийн бус бүсэд сонгогдсон цэг нь уул, толгодын ургамалжилт бүхий талбайд сонгогдсон тохиолдолд мониторингийн хийсний үр дүнд гарахгүй.

Олон нийтийн оролцоотой хяналт шинжилгээ

Ургамлын аймаг, ургамалжилтын хяналт шинжилгээг зөвхөн уурхайн талбайгаар хязгаарлахгүйгээр ойр орчмын иргэдийн оролцоонд тулгуурлан, өргөн хүрээтэйгээр явуулах боломжтой. Тухайлбал, нутгийн иргэд тэр дундаа уурхайн талбай болон түүний орчимд нутагладаг малчин иргэдтэй байгаль орчинд үзүүлж буй аливаа өөрчлөлтийг, ялангуяа ургамлан нөмрөгийн өөрчлөлтийг ажиглаж, илрүүлэн үнэн бодит мэдээллийг уурхайн байгаль орчны багийнханд тухай бүрт нь мэдээлэх талаар хамтран ажиллах зэрэг болно.

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Жинхуа орд” ХХК-ний уурхайн орчинд биологийн олон янз байдлын судалгаа, шинжилгээ хийх, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардлыг холбогдох аргачлалын дагуу тооцож оруулав.

Ажлын хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ	Нийт зардал	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	Дархан сумын нутаг	га	2.5		8 000 000	“Жинхуа орд” ХХК	-	-	
Нийт дүн					8 000 000				

Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд орсон 2012 оны нэмэлт өөрчлөлтийн дагуу уул уурхайн олборлолтын төслүүд жил тутмын байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний (БОНБНУ) тайландаа биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг тусгах шаардлагатай. Засгийн газрын 374/2013 тоот тогтоол, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А117/2014 тоот тушаалд дүйцүүлэн хамгааллын менежментийн гол зарчмууд болон аргачлалыг заасан. Шалгуур хангасан бүхий л төслийг биологийн олон янз байдлын бусад үнэт зүйлст байгаль орчны эерэг нөлөөлөл үзүүлэхийг эрэлхийлэх, хамгаалах эсхүл менежмент хийх замаар биологийн олон янз байдалд үзүүлэх үлдэгдэл нөлөөлөлд дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэхийг эдгээр эрх зүйн актаар шаардаж буй.

1. Уурхайлалтын нөлөөгөөр эвдэрсэн талбайг нөхөн сэргээх

Хэнтийн аймгийн БОАЖГ-н өгсөн саналын дагуу Хэнтийн аймгийн Дархан сумын нутагт уурхайн нөлөөгөөр эвдэрсэн 2.5 га талбайг нөхөн сэргээх болно.

8. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус уурхайн нийт 7 жил ашиглагдах бөгөөд уурхайлалт гүн рүүгээ явах тул ашиглалтын сүүлийн жилүүдэд техникийн сэргээн хийгдэх юм. Хэдий тийм боловч жил болгон нөхөн сэргээх боломжтой талбайг стандартын дагуу нөхөн сэргээх нь зүйтэй юм.

Ажлын хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ	Нийт зардал	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
Техникийн нөхөн сэргээлт	Уурхайн талбай	овоолго	-	10 000 000	“Жинхуа орд” ХХК	Нөхөн сэргээлтийн мэргэжлийн компаниуд			
Биологийн нөхөн сэргээлт		га	1	5 000 000					
Мод сөөг тарих		ш	100 ш	5 000 000					
Илүү ашиглалт талбайг чөлөөлөх ажил		га	2	2 000 000					
Илүү ашиглалт бүхий талбайн техникийн нөхөн сэргээлт		га	2	6 000 000					
Нийт дүн				28 000 000.0					

Илүү ашиглалт бүхий талбайн нөхөн сэргээлт


2023 оны 7-р сард батлагдсан БОННУ-ний тайланд оруулснаар нийт 6.7 га талбай илүү ашиглалт бүхий байгаа энэ зөрчлийг арилгаж нөхөн сэргээхээр тус БОННУ-д тусгасан болно. Иймд бид БОННУ-д тусгасны дагуу илүү ашиглалттай нийт 6.7 га талбайг нөхөн сэргээлтийн чиглэл, тооцоо, дараахь байдлаар орууллаа. Мөн 2023 оны 9-р сард тус талбайг чөлөөлөх ажлыг эхлүүлсэн бөгөөд чөлөөлөлтийг эхлүүлсэн баримт фото зургийг энэ хэсэгт орууллаа.

Хүснэгт 4.5. Газар чөлөөлөх ажлын график


№	Хийгдэх ажлууд	Хугацаа	Тайлбар
1	Чөлөөлөх бэлтгэл ажил	2023 оны 9-р сар	Энэ ажил хийгдсэн
2	Кемпын байгууламжыг шилжүүлэх	2024 оны 3-4-р сар шилжүүлэх	2024 онд хийгдэнэ
3	Баяжуулахын 1-2 шугамыг шилжүүлэх	2023.09-2024 оны 6-р сар	Энэ ажил эхлэсэн явж байгаа
4	Нөхөн сэргээлт	2024 оны 8-10-р сар	2024 онд хийгдэнэ
Нийт		2.1 жил	



Зураг.2. Илүү газар ашиглалтыг тодорхойлсон зураг



Зураг.3. Илүү газар ашиглалтыг тодорхойлсон дроны боловсруулалтын зураг



Зураг.4. Илүү газар ашиглалтыг тодорхойлсон дроны боловсруулалтын зураг



Зураг.5. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг,
2023-09-08



Зураг.6. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг,
2023-09-08



Зураг.7. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг,
2023-09-08



Зураг.8. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг,
2023-09-08



Зураг.9. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг,
2023-09-08

Нөхөн сэргээлт хийх чиглэл

Тус уурхайн нөхөн сэргээлтийг БОАЖЯ-ны 2015 оны 3-р сарын 30-ны өдрийн А-138 тоот тушаал, Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлалын дагуу хийж гүйцэтгэх болно. Нөхөн сэргээлт хийх чиглэл нь ХАА-н, ашиглах хэлбэр нь бэлчээрийн зориулалтаар ашиглах болно.

Техникийн нөхөн сэргээлт

Техникийн нөхөн сэргээлтийг MNS5917:2008 стандартын дагуу хийж гүйцэтгэнэ. Нийт талбайн хэмжээ 6.7 га байх болно. Техникийн зардлын тооцоог дараахь байдлаар үзүүлэв.

Нөхөн сэргээлт хийгдэх талбайг тэгшлэх ажлын зардал

Тоног төхөөрөмж болон барилга, байгууламжуудын талбай тэгшлэх ажлын зардал тооцё. Нийт тэгшлэлт хийх талбай: 2.8 га буюу 28000.м², нөхөн сэргээгдэх талбайд 0.2 м зузаантай хөрс чулуулгийг бульдозероор тэгшлэх ажил дахин хийгдэнэ гэвэл нийт тэгшлэх ажлын хэмжээ:

$$V_{\text{пл}} = 28000 \cdot 0.2 \cdot 1.05 = 5880 \text{ м}^3 \text{ болно.}$$

Хүснэгт.5.4. Бульдозероор тэгшлэх ажлын зардал (Б8К бульдозер)

Зардлын нэр	Томьёо	Тайлбар
Тэгшлэх ажлын хэмжээ: • эзлэхүүн м³ • талбай м²	$V_{\text{пл}} I = S_{\text{нийт}} \cdot h \cdot k_c$ $V_{\text{пл}} I$ – тэгшлэх ажлын эзэлхүүн хэмжээ, м³ S – тэгшлэх талбай, м² h – тэгшлэх хөрсний зузаан, см k – сийрэгжилт тооцох коэффициент	$V_{\text{пл}} I = 2.8 \cdot 10000 \cdot 0.2 \cdot 1.05 = 5880 \text{ м}^3$ $S_{\text{нийт}} = 2.8 \cdot 10000 = 28000 \text{ м}^2$
Талбай тэгшлэх үеийн бульдозерийн бүтээл, м²/цаг	$3600 \cdot L \cdot (I_x \sin \gamma - b) \cdot K_{\text{зан}}$ $S_T = n \cdot \left(\frac{1}{v} + t_э \right)$	$3600 \cdot 250 \cdot (1.17 \sin 30 - 0.4) \cdot 0.85$ $S_T = 2 \cdot \left(\frac{250}{100} + 60 \right) = 1132.2 \text{ м}^2$
Нийт ажиллах цаг	$T = \frac{S_{\text{нийт}}}{S_T \cdot K_{\text{зкс}}}$	$T = 5.19$
Түлш, ШТМ-ын зардал	$C_{\text{дт}} = T \cdot T_{\text{ц}} \cdot 1.15 \cdot P_{\text{дт}}$	$C_{\text{сд}} = 5.19 \cdot 90 \cdot 3.15 \cdot 1.7 = 2208505.5 \text{ төг}$

Сэлбэг	$C_{сз} = XO_{бульд} \cdot k \cdot t/T_k$	$C_{сз} = 2208505.5 \cdot 0.015 \cdot 5.19/4800 = 155819 \text{ төг}$
Цалингийн зардал	$C_{ц} = T \cdot Ц_{ц}$	$C_{ц} = 5.19 \cdot 10.5 = 57090 \text{ төг}$
НДШ	$C_{ндш} = C_{ц} \cdot 0.13$	$C_{ндш} = 57090 \cdot 0.13 = 7421 \text{ төг}$
Элэгдлийн зардал	$C_{эхш} = XO_{бульд} \cdot H_3 \cdot t/T_k$	$C_{эхш} = 503000 \cdot 0.1 \cdot 402/4800 = 4212.6$
Нийт бульдозерийн зардал	$C_{нийт\ бульд} = 2208505.5 + 155819 + 57090 + 7421 + 4212.6 = 2\,433\,048.8 \text{ төг}$	

Тэгшилсэн талбайг шимт хөрсөөр хучих ажлын зардал

Тэгшилсэн 6.7 га талбайг 10 см хөрсөөр хучихад $67000 \cdot 0.15 \cdot 1.05 = 10552.5 \text{ м}^3$ шимт хөрс хэрэгтэй.

Хүснэгт.5.5. Шимт хөрсийг овоолгоос утгуурт ачигчаар ачиж, тээвэрлэх ажлын зардал

Үзүүлэлт	Томъёо	Тооцоолол, тайлбар
Ачиж тээвэрлэх ажлын хэмжээ	$V_n = S_f \cdot h \cdot K_c$	$V_n = 10552.5 \text{ м}^3$
Утгуурт ачигчийн ачиж тээвэрлэх ажлын цагийн бүтээл	$Q_{уАц} = \frac{3600 \cdot K_{ца} \cdot E_{ам} \cdot K_{уд} \cdot \gamma}{\left(t + 3.6 \left(\frac{L_a}{V_a} + \frac{L_x}{V_x}\right) + t_B\right) \cdot K_C}$ $Q_{уАц}$ – утгуурт ачигчийн нэг цагийн бүтээл, м^3 $K_{ца}$ – цаг ашиглалтын коэф $K_{уд}$ – утгуурт дүүргэлтийн коэф, (0.8-1.2) t – ажлын мөчлөгийн хугацаа $t = 87.8 - 10.65q_a + 0.52q_a^2$ q_a – ачигчийн даац, тн L_a, L_x – ачаатай болон хоосон явах тээвэрлэлтийн зай, м V_a, V_x – ачаатай болон хоосон явах хөдөлгөөний хурд, м/сек $E_{ам}$ – тээвэрлэх үеийн утгуурын багтаамж, м^3 γ – тээвэрлэх хөрсний нягт, т/м^3 t_B – буулгах хугацаа K_C – сийрэгжилтийн коэффициент	$t = 87.8 - 10.65 \cdot 5 + 0.52 \cdot 5^2 = 45.55$ $Q_{уАц} = \frac{3600 \cdot 0.85 \cdot 3 \cdot 1.1 \cdot 1.8}{\left(45.5 + 3.6 \left(\frac{100}{11.5} + \frac{100}{16}\right) + 3\right) \cdot 1.05} = 159.5$
Нийт ажиллах цаг :	$T = \frac{V_n}{Q_{уАц} \cdot K_{экс}}$ T – Тухайн ажлыг хийж гүйцэтгэх цаг $P_{ц}$ – утгуурт ачигчийн нэг цагийн бүтээл, м^3 $K_{экс}$ – сийрэгжилтийн коэффициент	$T = 66.15$
	$C_{дт} = T \cdot T_{3ц} \cdot 1,15 \cdot P_{дт}$	

Түлш, ШТМ-ын зардал	C_{DT} – түлш, ШТМ-ын хэрэгцээ ТЗ _ц – цагт зарцуулах түлшний норм 1,15- ШТС-ыг түлшний зардлын 15%-иар Р _{дт} – 1л дизель түлшний үнэ, 1300 төг	$C_{DT} = 66.15 \cdot 15 \cdot 1.15 \cdot 1.7 = 1\,983\,984.8$ төг
